



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/375

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тасралтгүй тэжээлийн төхөөрөмж /ups 3ква/, 5 ширхэг нийлүүлэх ИНЕГ/ЦА/ТББ/Б-21/17 дугаар гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Б.Цогоо	Холбоо, навигаци ажиглалтын албаны Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн дарга
Гишүүд:	Д.Доржмягмар	Холбоо, навигаци ажиглалтын албаны Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн ахлагч инженер
	Э.Оргил	Холбоо, навигаци ажиглалтын албаны Ажиглалт, автоматжуулалтын хэсгийн инженер
	П.Сүхболд	Худалдан авах ажиллагааны тасгийн аэродромын инженер
	Д.Булган	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Дээрх ажлыг гэрээнд заасан тоо хэмжээ, бусад заагдсан шаардлагуудын дагуу шалгаж хүлээн авах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг Комиссын дарга /Б.Цогоо/-д даалгасугай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

Б.АЛТАНЦОМ